

# Монголын орон нутгийн мэдээ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

## Амилуулалтын баяр баясгалан

Далын Ахлагч Жосеф Чанг

**Т**эр (Есүс) энд байхгүй: Учир нь хэлж байснаараа Тэр амилсан” (Матай 28:5-6-г үз). Энэ бол өнөөг хүртэлх хүн төрөлхтөний түүхэн дэх хамгийн сэтгэл догдлом мэдээ юм!

Хятадын Сун эзэнт гүрэн мөхөх үед түүний үнэнч дагалдагч Вэн Тиансиан цаазлуулахаасаа өмнө дараах шүлгийг бичжээ:

*Өнэ эртний цагаас эхлээд, Үхэл гээчээс хэн зугтаж чадсан юм бэ? Үнэнч зүрх сэтгэл минь Хорвоогийн түүхийг гэрэлтүүлэх болтугай.*

(Вэн Тиансиан, 1236-1283, “Leaving Sea of Desolation.”)

Үхлийг зоригтойгоор угтсан Вэний түүх шиг түүхүүд бидний сэтгэлийг хөдөлгөдөг бол харин Христийн амилуулалт бидний зүрх сэтгэлийг урамшуулан зоригжуулдаг билээ. Үнэндээ “Бурхан бидний нүднээс нулимс бүрийг арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одсон” (Илчлэлт 21:4).

Шударга хүмүүн үхлээс айх хэрэггүй болохыг Христийн амилуулалт бидэнд баталсан. Есүс “. . . Сайн үйлийг

үйлдсэн хүмүүс нь амийн амилалт уруу, муу үйлийг үйлдсэн хүмүүс нь ялын амилалт уруу гарч ирнэ” (Иохан 5:29) хэмээсэн. Нүгэл хилэнц газар авсан энэ дэлхийд “сайн үйлс” ховордож, тэр ч бүү хэл сайн үйлсийг муу хэмээн гутаан доромжлох болжээ. Хүмүүс “муут сайн, сайныг муу” (Исаиа 5:20) гэх болсныг бид илүү ихээр харах боллоо.

Өөрийн амилалтаар Аврагч маань үхлийг ялан дийлснээ тунхагласан. Түүний заасан бүхэн үнэн бөгөөд Түүний амласан бүхэн биелэх болно. Энэ амлалт нь хэчнээн ихээр тайтгаруулан тайвшруулж, сэтгэлд урам зориг, хүч чадлыг өгнө вэ! Шударга журам нь нүгэл хилэнцийг давж; үнэн нь худлыг дийлэх болно. Өөрийн амилалтын буюу Аврагч тэнгэр лүү одсоны дараа Петр, Иохан нар Христийн амилуулалтын тухай зоригтойгоор гэрчилсэнд нь гайхах зүйл үгүй. Тахилч нар, сүмийн харуулын дарга бас садукайчууд Петр болон бусад элч нарыг барьж, байцаасан. “Эрдэм номгүй, боловсролгүй Петр, Иохан нарын ийнхүү зүрх зоригтой байгааг нь тэд хараад гайхацгаан, тэднийг



Есүстэй хамт байсныг нь мэдэв” (Үйлс 4:13). Тэд Петр, Иохан хоёрыг огт ярихгүй байхыг тушаасан ч Петр, Иохан нар тэдэнд “Та нарын үгийг Бурханыхаас илүүд үзэх нь Бурханы өмнө зөв

**Далын Ахлагч  
Жосеф Чан**

үү? Өөрсдөө шүүцгээ” (Үйлс 4:19) хэмээн хариулжээ.

Аврагч цовдлогдсоны дараа Америк тив дэх хүмүүс их салхи, газар хөдлөлт, түймэр, хуй салхи мөн байгалийн гамшгуудыг амсан, (3 Нифай 8) тэнд гурван өдөр харанхуй болж, “Мөн энэ нь өглөө байж, мөн уг нутгийн гадаргуу дээрээс харанхуй сарниж, мөн газар чичрэхээ больж, мөн хаднууд цуурахаа больж, мөн аймаар ёолон гаслах нь зогсож, мөн бүх үймээн шуугианууд нь улирч одов. Мөн газар дахин нэгдэн нийлснээс, энэ нь тэсэж өнгөрөв; мөн амь хэлтрүүлэгдсэн хүмүүсийн гашуудах нь, мөн уйлах нь, мөн ёолон гаслах нь зогссон болой; мөн тэдний гашуудах нь баясалд, мөн тэдний халаглах нь магтан дуулахад мөн Их Эзэн Есүс Христ, өөрсдийн Гэтэлгэгчид талархахад шилжсэн байв” (3 Нифай 10:9-10). Энэхүү гай гамшгийг даван туулсан зөв шударга хүмүүст амилуулалт нь санаанаас зохиосон эсвэл жирийн нэг цуу яриа биш байлаа. Тэдний баяр баясгалан болон хүлээн авсан баталгаа нь үгээр илэрхийлэхийн аргагүй агуу байсан биз ээ!

Ариун Сүнсний хүчээр бид бүгд Христийн амилуулалт бодит болохыг мэдэж чадна (Моронай 10:5,7-г үз). Аврагчийн амилуулалт ба Түүний Цагаатгал салшгүй холбоотой. Амилуулалт нь бидэнд Паулын: “Адам дотор

бүгд үхдэгчлэн Христ дотор бүгд амьдруулагдах болно” (1 Коринт 15:22) хэмээн хэлсэнчлэн ямар нэг болзолгүй, сул өгөгдсөн. Гэхдээ Цагаатгалын үр нөлөө нь бошиглогч Нифайн “Хүмүүн амьд Бурханы Хүүгийн жишээг дагахдаа эцсээ хүртэл тэвчихээс бусдаар бол, тэр аврагдаж чадахгүй” (2 Нифай 31:16) хэмээн заасанчлан болзолтой юм.

Хайрт ах эгч нараа, энэ Улаан өндөгний баярын үеэр бид Аврагчийнхаа амилуулалтын баярыг тэмдэглэнгээ Аврагчийн цагаатгах золиослол, Түүний үхлийг ялан дийлсэн мөн Түүний гайхамшигтай амилуулалтын талаар тунгаан бодоцгооё. Өөрсдөөсөө “Түүнийг дагах Христийн урилгыг бид хүлээн авах уу?” (Матай 4:19-г үз) хэмээн асууцгаая.

Их Эзэн хэлэхдээ Түүнийг дагасан хэн ч болов “тэр хүн энэ үед өчнөөн дахинаар хүлээн авч, ирэх үед мөнх амийг хүлээн авна” (Лук 18:30) гэсэн. Есүс Христийн сайн мэдээ энэ амьдралд олон адислалыг хүлээн авах боломжийг бидэнд олгодог. Жишээ нь, тушаалуудыг дагах нь уйтгартай тэр бүү хэл заримд нь хэцүү мэт санагдавч цаг хугацаа бидэнд “ёс бус явдал хэзээ ч аз жаргал байгаагүй” (Алма 41:10) тул тушаалуудад дуулгаваргүй байснаас тэднийг сахих нь амьдралыг илүү аз жаргалтай, амар хялбар болгодгийг

нотолдог. Хаан Бенжамин “Бурханы зарлигуудыг дагадаг тэдний адислагдсан мөн баярт байдлыг та нар тунгаагаасай хэмээн би хүснэ. Учир нь болгоогтун, тэд бүх зүйлд, биеийн мөн сүнсний аль алинд нь адислагдсан болой; мөн хэрэв тэд төгсгөл хүртэл итгэлтэйгээр тэвчвээс, тэгвэл тэд Бурхантай хамт хэзээ ч төгсөшгүй аз жаргалын байдалд оршиж болохын тулд тэд тэнгэрт хүлээн авагдах болно” (Мозая 2:41) хэмээн хэлсэн.

Тушаалуудыг сахиснаар хүлээн авдаг бас нэг адислал нь бусдад туслахад мэдэрдэг баяр баясгалан юм. Бусдын төлөө бүхнээ зориулан тусалдаг хүмүүс *авахаасаа өгөх нь илүүтэй адислагддаг* гэдгийг мэддэг. Бусдад туслах үедээ бид яг л эцэг эх үр хүүхдээ өөрийгөө мартан, эцэж цуцалгүйгээр хайрлахад мэдэрдэг тэрхүү дотоод сэтгэлийн аз жаргалыг амсдаг. Энэ дэлхий дээр өөрсдийн шашин шүтлэгийг хайхралгүй, хэн гэдгээ мэдэгдэлгүй, аливаа хариу нэхэл эсвэл шагнал горьдолгүй бусдад өгч, туслахыг хүсдэг олон хүн бий. Бид ийм хүмүүсийн өгөөмөр сайхан сэтгэлийг биширдэг. Тэд мөн бидэнд сургаал болон Есүсийн жишээнд илүүтэйгээр талархах сэтгэлийг төрүүлдэг!

Их Эзэн Петрт “чи нэгэн цагт дахин эргэж, ах дүүсээ батжуул” (Лук 22:32) хэмээн хэлсэн. Христ амилсаны

дараа Петр улам ихээр хөрвөгдөж, шийдэмгий болж, тэр үнэхээр Сүмийн олон гишүүдийг батжуулсан ажээ. Петр өөрийн илгээлтүүдийн нэгэнд, “Харин та нар зөвт байдлын төлөө зовлон эдлэхэд хүртэл хүрлээ ч, та нар ерөөлтэй. Тэдний сүрдүүлгээс бүү ай, бүү зов. Харин та нарын доторх найдварын талаар асуух хүн бүрд хариу өгөхөд, гэхдээ дөлгөөн байдалаар болон хүндэтгэлтэйгээр өгөхөд ямагт бэлэн байн, Христийг Эзэн хэмээж зүрхэндээ тусгаарлан нандигна” (1 Петр 3:14-15) хэмээн бичсэн байдаг.

Христэд итгэдэг хүмүүсийн хувьд бид “ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болж, үхэлд хүртлээ зогсоход бэлэн” (Мозая 18:9), бошиглогч Иосеф Смитийн хэлсэнчлэн “Бурханы хайраар дүүрсэн хүн гэртээ авсан адислалаа сэтгэл ханаад зогсохгүй харин бүх дэлхий даяар, бүх хүн төрөлхтнийг адислахыг хүсдэг” (*Сүмийн ерөнхийлөгчдийн сургаалаас: Иосеф Смит*, хуу. 426) байх ёстой. Товчхондоо Христийн сайн мэдээ нь орон гэрт нинжин сэтгэл, нийгэмд эв нэгдэл, дэлхийд амар амгаланг авчирдаг.

Бид Аврагчийн амилуулалтад талархаж байна. Бид энэ мэдлэгтээ баярладаг. Энэ нь биднийг Түүнийг дагах илүү их хүсэлтэй болгож, Түүнийг

мэдэж мөн Түүний үлгэр жишээг дагахад тусалдаг. Христ бидний төсөөллийг өргөн дээшлүүлж, хүмүүний мөн чанар нь хэчнээн цэвэр ариун, эрхэм хүндтэй бөгөөд бодгалиудын бодит үнэ цэнэ нь юу болохыг ойлгоход минь тусалсан. Түүнчлэн, Түүний сайн мэдээ бидэнд хүн төрөлхтөн хязгааргүй их нөөц боломжтой бөгөөд хэзээ нэгэн өдөр Түүнтэй мөн Тэнгэр дэх Эцэгтэй адил болж чадна гэдгийг заадаг. Орчин цагийн судруудын илчлэлтээр дамжуулан Тэрбээр бидэнд, “Ариун журам ариун журмаа хайрладаг; гэрэл гэрэлтэй нэгдэн нийлдэг; нигүүлсэл нигүүлслийн өрөвч сэтгэлийг агуулдаг” (С ба Г 88:40) хэмээн заасан. Ариун журмын үнэ цэнэ нь эд баялаг, мэдлэг, нэр хүндээс илүү давсан зүйл. Их Эзэн гаднах төрхийг бус зүрхийг хардаг (1 Самуел 16:7-г үз). Тэрбээр бидний сонгох эрхийг хүндэлдэг бөгөөд биднийг хүчилдэггүй. Тэрбээр хүмүүсийн Түүнд итгэх итгэлээр дамжуулан ажилладаг. Бид хэчнээн өчүүхэн ч бидний хүн нэг бүрт Тэр хайртай гэдгийг ойлгож ухаарахад минь тусалдаг. Бид мөнхөд аз жаргалтай байж болохын тулд Тэрбээр бидний төлөө үхсэн.

Бид бүгдээрээ Түүний нэрийг өөрсөд дээрээ авч, хамтдаа Түүнийг шүтэн бишрэх болтугай! ■

## Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Түүхээс

Улаанбаатар Баруун Гадасны түүхч  
А.Тунгалаг

**МонАхлагч Стэйтли Б.Смит ба Мажори В.Смит эгч, /1992 оны 9-р сараас 1994 оны 3-р сар/ нарын тэмдэглэлээс**

**1992 он – УЛААНБААТАР САЛБАР / АНХДАГЧДЫН ТҮҮХ/**

**1992.09.16** – Энэ өдөр Анхны номлогч гэр бүлийн хос Ахлагч Кеннет Х.Бийзли болон Донна Бийзли нар Монгол улсад ирсэн бөгөөд Хожмын Үеийн Гэгээнтэн Бизнесийн Коллежийн Ерөнхийлөгч асан Кеннет Х.Бийзли Удирдагч Ахлагчаар сонгогдсон байжээ.

**1992.09.20** – Анхны ариун ёслолын цуглаан Улаанбаатар хотын Сүхбаатар дүүрэгт болжээ. Цуглаанд Ахлагч Кеннет ба Систер Донна Бийзли мөн жуулчлалаар аялж байсан Бернард Веттер ах, Алета Веттер эгч нар оролцжээ.

**1992.10.04** – Бийзлийн гэр бүл дангаараа Цуглааныг явуулж, Ахлагч Кеннет Х.Бийзли “Монголд болох бүх Цуглааны хамгийн бага тооны гишүүд оролцсон цуглаан нь энэ байгасай хэмээн найднам” гэсэн байдаг.

**1992.10.11** – Салбарын Цуглаанд Кеннет Х.Бийзли болон Донна Бийзли, Ричард Г.Харпер болон Анна М.Харпер, Стэйтли Б.Смит болон Маржори В.Смит ах эгч нарын зургаан номлогч оролцсон байна. Энэ ням гарагт Ахлагч Ричард Г.Харпер Нэгдүгээр Зөвлөхөөр, Ахлагч Стэйтли Б.Смит Хоёрдугаар Зөвлөхөөр Ерөнхийлөгчийн Зөвлөлд дуудагдсан байна. Ахлагч Кеннет Х.Бийзли Солт Лейкээс ирэхдээ Ахлагч Бойд К.Пакер, Ахлагч Нийл А.Максвелл нараас ерөнхийлөгч болох адислалаа хүлээн авсан байжээ.

**1992.10.20** – Азийн Бүсийн Ерөнхийлөгч Монте Ж.Брау зочлон ирсэнд номлогчид маш их баяртай байсан бөгөөд онцгой сүнснийг мэдэрсэн байна. Тэрээр Монголын Засгийн Газартай байгуулсан чөлөөт тохиролцооныхоо нэг заалтыг тодруулж: “Хүмүүс номлогчдын хувиар ирж, манай итгэл бишрэлийн тухай зааж, Сүмийн Цуглааныг явуулж байхыг харилцан ойлголцсон юм” хэмээн хэлж байжээ.

**1992.10.29** – Ерөнхийлөгч Монте Ж.Брау Бүсийн Чуулган хийсэн нь номлолын зааварчилгаа болон гэрчлэл хүлээн авсан онцгой үе байсныг номлогчид дурсамжиндаа өгүүлсэн байдаг.

**1992.11.16** – Ахлагч Ройс П.Фландро болон Систер Мэри Жейн Фландро нар ирсэн ба Ахлагч Ройс П.Фландро салбарын гүйцэтгэх нарийн бичгээр дуудагдсан байна.

**1992.12.06–13** – Номлогчдын хувьд маш онцгой өдрүүд болсон нь анхны зочин Эрдэнэбат, мөн удаад нь “Америкийн мэргэжилтнүүд яах гэж Монголд ирсэн юм бол” хэмээн гайхдаг байсан Ахлагч Смитийн оюутнууд болох Даваажаргал буюу Сильвия, Батнасан, Пүрэвсүрэн, Батчулуун, Хүрэлбаатар нарын зургаан сонирхогч ирсэн байна.

**1992.12.06** – Энэ жилийн өвөл нилээд хохир хатуу болжээ. Номлогчид хоол хүнс, ундны усаар гачигдаж байх үед Бээжингийн салбарын Нийгмийн Халамжийн эгч нар ахмад номлогчдод зориулсан 150 кг хүнсний зүйл болон бэлэг бүхий ачаа тээсээр галт тэргээр ирсэн байна. Тэд Гленда Стийл, Конни Блэйкмор болон Карен Фалк нар байжээ. Номлогчид маань Бээжин дэх гишүүдийн бодож байсанчлан тийм их хэцүү байгаагүй ч, Бээжинд буй Гэгээнтнүүдийн



цуглуулан явуулсан гайхалтай илгээмжийг амталж, зоригт аялал хийсэн гурван эгчтэй уулзсан нь онцгой адислал байсан хэмээн дурьдсан байлаа.

**1992.12.20** – Маржори Смит эгч Монгол дахь салбарын анхны Нийгмийн Халамжийн Ерөнхийлөгчөөр дуудагдсан нь Христийн шашин шинэхэн үүсч буй нөхцөлд яггүй хариуцлага байсан гэдэг.

**Дархан-1 салбарт Нээлттэй хаалганы өдөр боллоо**

**Дархан салбарын Ахмад номлогч Бригтс эгч**

Хуучин Дарханд 10-р сарын 22-ны өдөр Дархан 1 ба Дархан 2 салбарынхан Нээлттэй хаалганы өдрийг зохион байгууллаа. Энэ нь цуглааны байранд болсон галын дэргэдэх ярилцлагаар эхэлж, гишүүд өөрсдийн Есүс Христийн Сэргээгдсэн сайн мэдээнд хөрвөгдсөн хувийн түүх болон гэрчлэлээ хуваалцлаа. Тэд галын дэргэдэх ярилцлагад оролцсон гишүүд болоод сонирхогч нарт Есүс Христ болон Мормоны Ном нь Есүс Христийн бас

*Сайн мэдээнээс хуваалцаж байгаа нь*

нэгэн гэрээ гэсэн хүчтэй гэрчлэлээ хуваалцав. Цугларагсад Дархан 1 салбарын Найрал дуучдын сайхан дуу хөгжмийг сонсож, сүнслэгээр өргөгдөн баяслаа.

Цуглааны байрын хашааг тойруулан цэнхэр бөмбөлөгөөр чимж, гудамжаар явж байсан хүмүүсийг урин дуудаж байлаа. Ахлагч болон Систер номлогчид бүх насны хүмүүсийг урин, Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн талаар илүү ихийг олж мэдэхийг уриалж байлаа. Сонирхогчид сайн мэдээний зурагнуудаар чимэглэсэн өрөөнүүдээр тойрон аялж, салбарын гишүүн тэдэнд Гэр бүлийн түүх, Залуу эмэгтэйчүүд ба Залуу эрэгтэйчүүд, Санваартан, Нийгмийн Халамж, Хүүхдийн хэсэг ба Ням гарагийн сургууль гэсэн Сүмийн хөтөлбөрүүдийн талаар танилцуулж байв.

Мөн тэдэнд баптисмын сангийн дэргэд зогсон, баптисмын үйл ажиллагаа болон Есүсийн адил баптисм хүртэх шаардлагын талаар заав. Зочид маань харж, сонссон зүүлдээ сэтгэл хангалуун, ихээр догдолсон харагдана.

Нээлттэй хаалганы үеэр далан таван хүн номлогчдод өөрсдийн нэр, хаяг, утасны дугаараа бичүүлж, сайн мэдээний талаар илүү их суралцахыг хүссэн юм.

Нээлттэй өдрөөр сүмийн гишүүд хөнгөн зууш бэлтгэн тавьсан байлаа. Ирсэн зочид маань тэдгээрээс амсан талархаж байв. Салбарын гишүүд болоод бүрэн цагийн номлогчдын бэлтгэл болон уйгагүй үйлчлэлийн хүчээр үйл ажиллагаа маш их амжилттай болж өнгөрлөө. Та нарынхаа гайхамшигтай үйлчлэлд баярлалаа. ■



**Олон сонирхогчидтой боллоо**

# Дезерет Олон Улсын Энэрлийн Байгууллагын Үйл Ажиллагаанаас

Хүүхдийн гэр

**2011** оны 11 дүгээр сарын 22-ны өдөр Сонгино Хайрхан Дүүргийн 8-р хороонд байрлах Хүүхдийн Гэр сургууль дээр хэрэгжсэн төслийн хаалтын үйл ажиллагааг зохион байгуулав. Дээрэт Олон Улсын Энэрлийн Байгууллага нь тус сургуульд суралцаж 40 хүүхдэд зориулан нийт 1 сая 262 мянган төгрөгний өртөг бүхий хөлдөөгч, зуух, ширээ, гал тогооны хэрэгслүүд, ногоо хэрчигч, махны машин, хоолны болон цайны аяга, халбага хандивлаж, нийт 16 цагийн сайн дурын үйлчлэл хийлээ. Уг сургуулийн багш Мөнхтунгалаг, Сарантуяа нар барааны үнийг судалж, худалдаж авах ажлыг гардаж хийсэн юм. Хаалтын үйл ажиллагаанд Сүмийн Олон Нийтэй харьцах албаны ажилтан У.Соёлмаа, Бишоп Ганпүрэв, Оюунтуяа (8-р хорооны ИТХ-ын дарга), Батханд, Ахлагч Ричардсон болон Ричардсон эгч түүнчлэн хамгийн чухал хүмүүс болох 17 сурагч оролцов. Уг сургуульд суралцаж буй хүүхдүүд жирийн сургуульд буцаж орон, ЕБС-ийн гэрчилгээ авах боломжтой. 19 хүүхэд энэ сургуулийг төгссөн бөгөөд тэднээс 17 нь их сургуульд, 2 нь коллежид сурч



Хүүхдүүд ангидаа



Бяцхан гал тогоо


байна. Сургуулиа дэмжихийн тулд сурагчид эсгийгээр төрөл бүрийн зүйл урлахыг заалгадаг. Тэд ноос самнаж, эсгий хийгээд дараа нь сайн чанарын бүтээгдэхүүнүүдийг хийж зардаг бөгөөд тэдний хийсэн дөрвөн хөл нь унжсан хурганууд нь их хөөрхөн. Түүнчлэн тэд амьтад, цүнх, дэрний уут, жижигхэн гэр, гацуур модны чимэглэл, углааш, гал тогооны бариул, бээлий зэргийг сайн чанартайгаар хийдэг. Хавар бүр хүүхдүүд хашаандаа байрлах хүлэмж болон ногооны талбайдаа өргөст хэмх, чинжүү гэх мэт ногоо тарин, салат хийж, ногоо дарах аргад суралцдаг. Дарсан ногоогоо өвлийн турш үдийн хоолондоо хэрэглэдэг. Хэдэн өдрийн өмнө ахмад номлогч нар болох Ахлагч Форд, Форд эгч, Ахлагч Хант, Хант эгч, Ахлагч Ричардсон, Ричардсон эгч нар орчуулагч Батхандын хамт уг сургуульд зочилсон юм. Тэд хүүхдүүдээс эрүүл ахуйн (гар болон хувцасаа угаах, бусдын аягыг яагаад хэрэглэж болохгүй талаар) дөрвөн асуулт бүхий тест авч, тэдэнтэй цагийг хөгжилтэй өнгөрүүлсэн юм. Хүүхдүүд асуултанд хариулснаар жигнэмэг, боов, ундаа шоколад зэргээр шагнуулсан. Хүүхдүүдийн өвлийн амралт таарсан байсан хэдий ч тэд бидэнтэй уулзахаар ирсэн байсан бөгөөд үнэхээр хөгжилтэй байлаа. ■

## ГЭГЭЭНТНҮҮДИЙН ДУУ ХООЛОЙ

Зүүнхараа салбар(2011 оны Залуучуудын Чуулган)

**Б**и сүм ороод одоо жил хоёр сар болж байна. Би Мормоны Номны тухай гэрчлэл хуваалцмаар байна. Өдөр бүр Мормоны Номноос уншиж, унших бүр хүчтэй гэрчлэлийг хүлээн авдаг. Энэ номыг дахин дахин уншихыг л хүсдэг. Мормоны Номноос би шударга байх, дуулгавартай байдал ба адислалыг хэрхэн авах тухай болон бошиглогчдын үгс биелдэг гэсэн гэрчлэлийг олсон. *Отгонцэцэг*

Би 2009 – 2011 онуудад бүрэн цагийн номлолд үйлчлээд бууж байгаа юм. Зүүнхараа салбараас бууж, салбарын ерөнхийлөгчөөр дуудагдан ажиллаж байна. Тэгээд залуучуудтайгаа энэ чуулганд оролцож байна. Энэ чуулганд зөндөө их зүйлийг нэмж сурлаа. Онцгойлон ялангуяа Хулан багшийн “Ариун журам”-ын тухай хичээлээс их зүйлийг сурлаа. Ариун журамтай байхын тулд бид юу хийх ёстой вэ? Ариун журамтай хүмүүс буюу тийм жишгүүдтэй хүмүүстэй нийлснээр илүү юу сурч болохыг сурсан. Энэ нь миний амьдралтай ойр байлаа. Би энэ сүм үнэн гэдгийг мэддэг. Мормоны Ном бүх дэлхий дээрх номнуудаас хамгийн үнэн нь гэдгийг би мэднэ, энэ бол миний гэрчлэл. *Батцэнгэл, Салбарын ерөнхийлөгч*



Отгонцэцэг



Батцэнгэл,  
Салбарын  
ерөнхийлөгч

Би сүмд ороод жил гаруй болж байна. Өртөөлчилсэн сургалтаас наманчлалын талаар их зүйл сурсан. Мөн сүмийн хүүхдүүдтэй найзлах нь жирийн сүмийн бус хүүхдүүдтэй найзалснаас шал өөр байдаг. Сүмийн хүүхдүүд илүү журамтай, зөв байдаг. Энэ сүмд би дуртай. *Ганчимэг*

Би 17 настай Сүмийн гишүүн болоод 2 жил хагас болж байна. Гайхалтай ах эгч нар олон сайхан, гоё хичээлүүдийг заасан. Цэвэр ариун байдал зэрэг олон зүйлийг сурсан. Ялангуяа наманчлалын талаар надад илүүтэй таалагдсан. Бид бүх үйлдэл, бодол санаагаараа зөв, ариун байх ёстой. Жаахан ч гэсэн буруу зүйлийг хийвэл энэ нь нүгэл. Тиймээс өдөр тутмынхаа үйлдлийг хянах хэрэгтэй. Наманчлал нь надад Есүс Христийн Цагаатгалыг сануулсан. Манай сүм гайхамшигтай сүм, Мормоны Ном Бурханы судар сургаалууд бөгөөд хүмүүст нөлөөлж чаддаг гэдгийг би мэддэг. *Мөнхзул*

Анх удаа залуучуудын чуулганд явсандаа маш их баяртай байна. Сүмийн хүүхдүүдийн үерхлийг харж гайхширч сууна. Үнэхээр сайхан, цэвэрхэн үерхэл байдаг юм байна. Үүнийг энэ чуулганаас хараад баясаж байна. Би Бурхан амьдыг мэднэ. Есүс Христ бидний төлөө амиа золиосолсон. Хэрэв энэ сайн мэдээг амьдралдаа олоогүй бол төөрсөн хүмүүс л байх байлаа. Энэ үнэн сүмд орсондоо баяртай байна. Бас саяхан охин маань

баптисм хүртэж, сайн мэдээг хүлээн авсанд маш их баяртай байгаа. Энэ сүм үнэн бөгөөд Бурханы үгс бидний амьдралын заавар гэдгийг гэрчилж байна. *Алтанзул салбарын 2-р зөвлөх* ■



*Мөнхзул*



*Ганчимэг*



*Алтанзул, Салбарын 2-р зөвлөх*



*Зүүнхараа салбарынхан*